

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо:2021.04.25

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Аудитын код:	САГ-2020/26/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Б.Эрдэнэзул

**Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл**

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Төсвийн шууд захирагч	54	48	2	4		43	4	1	
2	Төрийн өмчит аж ахуй нэгж, байгууллага	4	4				3	1		
3	Засгийн газрын тусгай сан	2	2					1		1
	<b>Дүн</b>	<b>60</b>	<b>54</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>46</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>1</b>

**Гурав. Аудитын үр дүн**

**3.1.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

*(сая төгрөг)*

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:						Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТШЗ	86	1,385.5	16	23.4	23	875.5	47	486.6		
2	ТӨААНБ	27	6,548.7	2	3.5	8	4,855.3	17	1,689.9		
	ЗГТСан	15	232,202.2			14	232,202.2	1			
3	Төсвийн төвлөрүүлэн	114	2,719.3	18	23.2	36	754.4	60	1,941.7	1	4.6
4	ТЕЗ	4				2		2			
	<b>Дүн</b>	<b>246</b>	<b>242,855.7</b>	<b>36</b>	<b>50.1</b>	<b>83</b>	<b>238,687.4</b>	<b>127</b>	<b>4,118.2</b>	<b>1</b>	<b>4.6</b>

## **3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл:**

### **Алдаа, зөрчилтэй асуудал 1.**

ХААДС-ийн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, зарим дансны үлдэгдэл болон ажил гүйлгээ нь хангалттай, зохистой баримтаар нотлогдоогүй тул АДБОУС-ын дагуу дүгнэлт өгөхөөс татгалзсан, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчил илэрсэн байна.

Энэ нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тооцсон материаллаг байдлын түвшингээс давж, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д *“өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”*, 14.2.10-т *“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### **Алдаа, зөрчилтэй асуудал 2.**

Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 139 мэдээлэл байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”*, 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.1.6-д *“төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### **Алдаа, зөрчилтэй асуудал 3.**

Харьяа төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 262,428.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 19,572.3 сая төгрөгийн 92 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 242,855.7 сая төгрөгийн зөрчилд 50.1 сая төгрөгийн 36 төлбөрийн акт тогтоож, 238,687.4 сая төгрөгийн 81 албан шаардлага хүргүүлж, 4,118.2 сая төгрөгийн 125 зөвлөмж өгчээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д *“өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”*, 14.2.10-т *“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”*, 27 дугаар зүйлийн 27.1.1-д *“төсвийн зарчмыг мөрдлөг болгох 6 дугаар зүйлийн 6.6.1-д төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”* гэж заасантай нийцээгүй, *“Үнэн зөв байдал”*, *“Эрх ба үүрэг”*, *“Оршин байх”*, *“Иж бүрэн байх”*, *“Толилуулга ба Тодруулга”* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээг авах зөвлөмж өгсөн.

### **Алдаа, зөрчилтэй асуудал 4.**

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнахдаа Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бараа материалын дансны үлдэгдлийг төсөвт байгууллагуудад мөрдөгдөх дансны ангиллаар, зарим бараа материалын үлдэгдлийг дансны ангилал

зөрүүлэн бүртгэсэн байна. Мөн бусад биет бус хөрөнгийн дансанд программ хангамжийг бүртгэн, үндсэн хөрөнгийг дансны ангилал буруу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” гэж заасантай болон, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-тай тус тус нийцэхгүй, “Толилуулга ба тодруулга”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал, үндсэн хөрөнгийг холбогдох стандарт, батлагдсан дансны ангиллын дагуу үнэн зөв ангилан бүртгэж, тайлагнаж байх зөвлөмж өгсөн.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ГИШҮҮН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД  
З.МЭНДСАЙХАН ТАНАА

2021.04.26 № 1325  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 242,855.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй, тодорхойгүй, найдваргүй авлага, өглөг үүссэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалтын горим зөрчигдсөн, эзэмшлийг шилжүүлэн аваагүй, төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зэрэг алдаа, зөрчлүүд нь УСНББОУС болон Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журам, зааварт нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг", "Оршин байх", "Иж бүрэн байх", "Толилуулга ба Тодруулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ